Орон бүхний пролетари нар нэгдэгтүн!

# Анхдугаар ТАВАН ЖИЛ

ТӨВ АЙМГИЙН НАМЫН ХОРОО, А Д. Х. Г. ЗАХИРГААНЫ СОНИН

16 дахь жилдээ
№ 26 (1361)

1964 оны
3 дугаар сарын 30

ДАВАА

## Өсвөрийн үеийнхний хүмүүжилд байгууллага, хүн бүр жигд анхааръя

МАХН, өсвөрийн үеийнхний хүмүүжлийг бүх нийтийн хэрэг болгон дэвшүүлсэн нь манай аймгийн нам улс, олон нийтийн бүх байгууллага хөдөлмөрчдийн идэвх санаачлагыг өрнүүлэв.

Үүний дунд шинэ шинэ хэлбэрийн ажил зохиогдож нийт сургууль, цэцэрлэгийн соёлч боловсон байдал, хүмүүжил эрс дээшлэн, гэмт хэрэг, элдэв зөрчил гаргах явдал багасаж байна.

Аймгийн үйлдвэрлэлийн холбоо, нийгмийн аюулаас хамгаалах аппаратын газар, харилцаа холбоо, Жаргалантын сангийн аж ахуй, соёлын ордон, номын сан, харилцаа холбоо, сонины газар зэрэг албан газар, соёл урлаг, үйлдвэрийн газрууд хүүхдийн кино театр, номын сан, радио станц, хэвлэлийн дугуйланг ажиллуулж, өөрсдийн харъяаны ажилчдынхаа хүүхдийн бүртгэл судалгаа гаргаж, фото самбар хийж эх эцэг хүүхдүүдэд зөвлөлгөө өгөх булан байгуулж яриа хийх, кино үзүүлэх, тэргүүний эх эцгийн туршлага дэлгэрүүлэх, эх эцгийн зөвлөл байгуулан ажиллах болов.

Жаргалантын сангийн аж ахуйн намын хороо, хүүхэд хүмүүжүүлэх талаар намын гишүүдэд семинар өгч, намын гишүүд багш нарт айл өрх хариуцуулан судлах сурталчлах ажил хийж 7 хоног тутамд сурагчид, эцэг эхэд зориулсан нэвтрүүлэг явуулах хэд хэдэн газар гэгээрлийн хурал зохиосон байна. Энэ сангийн аж ахуйн сургууль, багш нар идэвхтэн сурагчид фото зурагчдын бүрэлдэхүүнтэй сурагчдын ирц бүртгэх хэсэг, үлгэрийн танхим байгуулан ажиллаж байгаа нь зохих үр дүнгээ өгч байна.

Өнжүүл сумын цэцэрлэгийн хүмүүжүүлэгч Чанцалсүрмаа, төвийн 2 дугаар цэцэрлэгийн хүмүүжүүлэгч Цэгмэд. Сүхтөмөр, 1 дүгээр цэцэрлэгийн хүмүүжүүлэгч Раднаа нар хичээл хүмүүжлийн ажлыг үзүүлэн таниулах материалтай зааж, өглөөний гимнастикийг тоглоомтой хослон, анги бүрт өглөөлөг зохиож, хүүхдийн авъяас чадварыг улам хөгжүүлж байна. Жаргалантын 11 жилийн сургуулийн багш Шагдарсүрэн, ангийнхаа сурагч нэг бүрт судалгаа хөтлөж, хэсгийн давтлага зохиох, сайн талын хэвшлийг эзэмшүүлэх, сул дүн авагчдад судлах дэвтэр хөтлөн, давтлагыг урилгатай зохиох, өчүүхэн ч атугай дутагдал гаргасан сурагчийг тэр өдөрт нь хамт олноор хэлэлцүүлэн буруугий нь ойлгуулах зэргээр ажилласнаас эдний анги 6 улирал дараалан 100 хувь сурч, зөрчилгүй анги болжээ.

Ингэж социализм-коммунизм байгуулах ирээдүйн иргэд багачуудын эрүүл энх, өсөлт бойжилт, зөв боловсон хүмүүжилтэй, чанартай сайн сурлагатай, хөдөлмөрийн дадлага чадвартай болгон хүмүүжүүлэхийн төлөө зарим газар хүмүүс, их ажил хийж байна. Үүний хажуугаар их яриа, шуугиан дэгдээж, эх эцгийн зөвлөл байгуулсан төдийхнөөр ажлаа хязгаарлаж, санаа тайвшран, сэтгэл амирлангуй сууж байгаа албан үйлдвэр, соёлын газар мэр сэр байгааг дурьдалгүй өнгөрч болохгүй. «Хүүхдийн хүмүүжлийн ажил бүх нийтийн анхаарлын төвд байх ёстой» гэсэн, нам, засгийнхаа мэргэн заалтыг биелүүлэхгүй байгааг тэвчиж түүнтэй хэзээд ч эвлэрэх ёсгүй. Хүүхдийг хүмүүжүүлэхэд байгууллагын ажлын төлөвлөгөөнд заавал нэг зүйл тусгагдсан, олон хүүхэд суралцдаг байгууллагуудад эцэг эхийн зөвлөлийг байгуулж хичээл хүмүүжлийн ажлыг удирдан явуулж байвал зохино.

Сайн сурагч, эцэг эхийн туршлага дэлгэрүүлэх, сул сурлагатан сурагч түүний эцэг эхийн ажиллагааг сайжруулах талаар нам, улс, олон нийт, гэгээрлийн байгууллагууд жигд эрчимтэй орж ажиллах ёстой. Байгууллага бүр хүмүүжлийн нэг өдрийг бий болгох хэрэгтэй байна.

Сурагчдын дотор биен тамир спортын тоглоомууд явуулах төрөл бүрийн аврагуудыг шалгаруулах дуу, бүжиг, шүлэг заах, эцэг, эх, сурагчдын хамтарсан зугаалга экскурс зохиох нь чухал.

Ажилтан, ажилчдын ажлыг дүгнэхдээ хүүхдийн хүмүүжлийн асуудалд хир зэрэг санаа тавьж ажилладгаар нь дүгнэх нь зүйтэй. Эвлэл, пионер, соёл гэгээрлийн байгууллагууд сургууль цэцэрлэгүүдийн хичээл хүмүүжил, дотоод ажиллагааг шалгаж мэргэжлийн талын гүн туслалцаа байнга үзүүлж үндэсний ба европ хөгжим, хүүхдийн найрал, гоцлол дуу, бүжиг, жүжгийн дугуйлангууд, кино, дүрслэх урлал, фото салбаруудын дэргэд гар зураг, кино механикч фото баримал, хүүхдийн номын булан байгуулж ширээ, сандлуудыг эрүүл ахуйн шаардлагат тохируулан бэлтгэж өгөх хэрэгтэй байна.

Байгууллага, хүн бүр, хүүхдийн ирээдүйн сайн сайхны төлөө, эрүүл энх өсөлт, бойжилт зөв боловсон хүмүүжил, сурлагын төлөө санаа тавьж, Намын Төв Хорооны захидал, «үнэн» сонины хурлын материалуудыг бүх ажилчин албан хаагчдаараа судлуулан шалгалт авч, сургууль, цэцэрлэгүүд бүтээлчээр тусган хэрэглэж, тусгай төлөвлөгөөтэй ажиллах явдал чухлаар шаардагдаж байна.

## МӨНГӨНМОРЬТ СУМ, АЙМГИЙН ҮЗЛЭГ ШАЛГАЛТАНД БЭЛТГЭЖ БАЙНА

Аймгийн намын хорооны товчоо, зааварлагчдын групп шалгалтыг 3 дугаар сарын сүүлчийн 10 хоногт аймгийн зүүн таван суманд явуулах тухай тогтоол гаргасан билээ.

Намын хорооны энэ тогтоолыг биелүүлэх, групп шалгалтанд сайн дүн үзүүлэх зорилгоор Мөнгөнморьт сумын намын үүрийн товчоо, сумын АДХ—ын Гүйцэтгэх Захиргааны гишүүдийн хавсарсан хурлаар хэлэлцэн групп шалгалтанд бэлтгэх сумын төлөвлөгөөг баталжээ.

Төлөвлөгөө ёсоор төлийн бойжилтонд онцгой анхаарч төлийг гарздалгүй бойжуулах нэг дүгээр улирлын төлөвлөгөөт ажлыг нэр төрлөөр нь биелүүлэх, албан байгууллага, нам, олон нийтийн бүх байгууллага нэгдлийн бригад, фермүүдийн дотоод ажлаа эмхлэн цэгцлэх, намын суртал ухуулгын ажлыг улам сайжруулах зорилгоор хэсгийн ухуулагчдын нэг өдрийн семинарыг бригадуудын төвд хийжээ.

Суурийн хүмүүжлийн ажлыг тогтмолжуулан сайжруулах, хот, суурь, бригадуудыг тохижуулах, хэвлэл тараалтыг шуурхай болгох, боловсон хүчнүүдийн ажлын хариуцлагыг өндөржүүлэх цаг ашиглалт, сахилга батыг сайжруулах зэрэг асуудлаар сумын намын үүрийн товчоо, АДХ—ын Гүйцэтгэх Захиргааны урьдчилсан үзлэгийг бүх албан газар, бригад фермүүдэд зохион явуулж байна.

Аймгийн үзлэгт сайтар бэлтгэж сайн дүгнэлт авах нь 1964 оны улс ардын аж ахуй, соёлын төлөвлөгөөт бүх зорилтыг хугацааны нь өмнө давуулан биелүүлэх чухал үндэс болно гэж тус сумынхан шуурхай бэлтгэж байна.

П. Сумхүү

## АЙМГИЙН НАМЫН IV БҮГД ХУРАЛ ХУРАЛДАХ БОЛЛОО

Аймгийн намын хорооны товчоо IV бүгд хурлыг 1964 оны 4 дүгээр сарын 20—ны өдөр хуралдуулах тогтоол гаргав.

Аймгийн Намын Хорооны IV бүгд хуралд «Үхэр сүргийн үржлийн ажлыг сайжруулж, сүүний гарцыг нэмэгдүүлэхэд аймгийн намын байгууллагын зорилтын тухай» асуудал хэлэлцүүлэхээр шийдвэрлэж, илтгэгчээр нь аймгийн намын хорооны нэг дүгээр нарийн бичгийн дарга Б. Дэжидийг баталсан байна.

## ШЕФИЙН ХОЛБООНЫ БЭХЖИЛТ

БНМАУ—ын Эрүүлийг Хамгаалах Яам, Бүрэн сумын «Бүрэндэлгэрэх» нэгдэлтэй 1961 оноос эхлэн шефийн холбоо тогтоож эд материал, ажилчдын хүчээр орчин үеийн төхөөрөмжөөр бүрэн тоноглогдсон төрөх тасаг, халуун усны барилга барьж мөн 6 ханатай гэр өгсөн байна.

Жил бүр 1—2 удаа их, бага эмчийн бүрэлдэхүүнтэй 1000-аас доошгүй төгрөгний эмийн сантай «Эрүүл энхийн» бригадууд ирүүлэн сумын төв, бригад суурийн малчдад эмнэлгийн биечилсэн тусламж үзүүлсээр байна.

Мөн «Л—6» мотор өгч цахилгаан гэрлээр хангасан байна.

Жил бүр төлийн бэлтгэлд зориулан төл амлуулах янз бүрийн 500—1000 төгрөгний эм хэрэглэл, элгэвч, нэмнээ, угж, 500—1000 ширхэгийг өгч байна.

Жил бүр 15—30 хүний бүрэлдэхүүнтэй туслах хугацаатай бригадууд 20—30 хоногийн хугацаатай 1—2 удаа ирүүлж хашаа барих, хадлан авах, тариа хураалтын ид үед ажиллуулж байна.

Энэ жил цас зудын гачаалтай хүнд үед 3—5 ачааны машин, ажиллах хүний хамт 10—30 хоногийн хугацаагаар нэгдлийн мэдэлд өгч хашаа саравчны мод татах, нүүрс тээвэрлэх, хол ойрын тээвэрт ажиллуулж нэгдэлд их хэмжээний төгрөгний хэмнэлт гаргав. Тус нэгдлийн гишүүдийн соёлжилтонд зориулан баяр ёслол, тэмдэглэлт өдрүүдэд урлагын бригад, сурталчлах бригадууд ирүүлэн, ном товхимол, айл өрх суурийн хүмүүст тараан судлуулах ажил зохиох, нэгдлийн тэргүүний сайчуудыг шагнаж урамшуулах, Яамны зардлаар Улаанбаатар хотод аваачиж нийслэлийн хөгжилт, үзвэр үйлдвэрийн газруудыг үзүүлэн малчдад оюун санааны сайхан туслалцаа үзүүлдэг байна. Саяхан 12 хүн ирж төв хөдөөгийн хүмүүст эмнэлгийн тусламж үзүүлж нэгдлийн гишүүдэд 2 мянган төгрөгийн эм үнэ төлбөргүй олгож, төлд зориулан угж, элгэвч, нэмнээ мянга гаруй бор эсгий 5 ширхэг, гэрийн хана 10 ширхэгээр туслав.

Мөн ачааны машин 3—ыг 20 хоногийн хугацаагаар төлийн хайс, өвс, малын хашааны мод татуулахаар нэгдлийн мэдэлд өглөө.

Ингэж ажилчин, малчны холбоо улам бэхжиж тус сум сүүлийн 4 жил дараалан малаа 5 төрөл дээр нь 103—105 хувиар өсгөж бусад аж ахуй соёлын төлөвлөгөөт зорилтуудыг амжилттай биелүүлж аймагтаа тэргүүний сум нэгдлийн тоонд орсон юм.

С. Дашдэндэв Д. Найдан
(Идэвхтэн сурвалжлагч)

